



**ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО**

14191, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 55,

Утас: 262449, 266246 Факс: (976-11) 32 52 34

И-мэйл: info@sport.gov.mn

2022.11.25 № 1/1015

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2022 оны жилийн эцсийн биелэлт, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хавсралт ¹⁵ хуудастай.

ДАРГА



Д.ЖАРГАЛСАЙХАН

14229105

**АЛСЫН ХАРАА – 2050
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО
2022 оны жилийн эцэс**

2022.11.23

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)	Биелэлтийн хувь
				Он	Түвшин			
ЗОРИЛГО 1. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ								
1.	Зорилт 1.5. Дэлхий дахинд монгол үндэсний үнэт зүйлсийн дархлаа тогтож, монгол соёлыг түгээн дэлгэрүүлж, Монгол Улсын нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлж, хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатны хамтын ажиллагаа төлөвшинө.							
1.1.	Арга хэмжээ 1.5.12. Монголын уламжлалт спорт, наадам, наадгайг (бөх, сурын харваа, шагайн харваа гэх мэт) хөгжүүлэх, үндэсний баг, тамирчдаа дэмжих, морин болон тэмээн спортын (морин поло, тэмээн поло) төв байгуулж үндэсний багтай болох, гадаад, дотоодын баг, тамирчдыг урьж тоглуулах тогтолцоог хөгжүүлж, спортын зарим төрлийг олон улсын болон олимпын төрөлд оруулах, түүгээр дамжуулан өөрийн орны соёлыг түгээн дэлгэрүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.	Улсын төсөв	-	Үндэсний спортын төв байгуулах боловсруулсан байна.	Үндэсний спортын төв байгуулах ажлыг эхлүүлсэн байна.		Үндэсний спортын төвд бие даасан спортын төрлийн задгай талбайг байгуулахаар төлөвлөсөн ба шагайн харваа, мөсөн сурын спортын холбооноос зураг төслийн даалгаварт тусгуулах талбайн стандарт хэмжээ, ерөнхий төлөвлөлтийн зургийн талаарх мэдээлэл ирүүлсэн. Морин уралдаан, жороо морь, ширээний шагай, халх сурын харваа, буриад сурын харваа, морин харваа, уран уургагч, эмнэг сургагч, тэмээн поло спортын холбоод зураг төслийн даалгаварт тусгуулах санал, мэдээллийн боловсруулалт хийгдэж байна. “Үндэсний спортын төв”-ийг байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах асуудлыг Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах бөгөөд тус төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлагдсаны дараа Нийслэлийн Засаг даргын тамгын газар, “Монгол наадам” нийслэлийн өмчит үйлдвэрийн газартай хамтран техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах асуудлыг шийдвэрлэхээр тохиролцсон.	30%

ЗОРИЛГО 3. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

2.	Зорилт 3.5. Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ.									<p>Эртэч нийгэм, эртэч иргэн, гэр бүлийг би болгох зорилгоор "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аяныг 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс 06 дугаар сарын 1-ны хооронд өдөр бүр 06.30-07.30 цагт бүх насны иргэд дасгал хөдөлгөөнөөр цахимаар хичээллэх орчныг бүрдүүлсэн. Нийт ажлын 74 хоног 4320 минутын дасгал хөдөлгөөнийг спортын төв ордны "А" заалнаас шууд дамжуулж 21 аймаг, 9 дүүргийн 1650 гаруй цэгт иргэдэд цахимаар дасгал хөдөлгөөнийг зааж улсын хэмжээнд давхардсан тоогоор 1,605,341 иргэн өглөөний дасгалд хамрагдсан байна. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол Хүн Хөдөлгөөн"-ийг Баянхонгор аймагт зохион байгуулаа. Энэ үеэр Хөл бөмбөгийн "Грассруүгс" сургалт, Хөл бөмбөгийн фестиваль, Сагсан бөмбөгийн 3х3 сонирхогчдын тэмцээн, Сумын арга зүйч нарийн сургалт, Идэвхтэй хөдөлгөөний флэш моби, биеийн тамираар хичээллэж "илүүдэл жингээ хассан 1 иргэн", "харвалтын дараа идэвхтэй хөдөлгөөнөөр эрүүлжсэн 1 иргэн", "идэвхтэй хөдөлгөөнөөр чихрийн шинжин өвчнөөс ангижирсан 1 иргэн"-ий жишээгээр контент бэлтгэж иргэдэд сурталчлах ажлуудыг зохион байгуулж дээрх арга хэмжээнд 489 хүн хамрагдлаа.</p> <p>Монгол Улсын хэмжээнд 3-64 насны 347237 иргэн бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдлаа. Үүнээс 166042 нь эмэгтэйчүүд 47.8%, 181195 эрэгтэйчүүд 52.2% тус тус эзэлж байна. Хамрагдсан нийт иргэдээс</p>
2.1.	Арга хэмжээ 3.5.1. Биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгох, иргэн, гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн идэвхтэй амьдралын дадал хэвшил төлөвшүүлэх туршийн боловсролын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	Улсын төсөв	-	Эрх зүйн орчин бүрдүүлсэн байна.	Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт 57 хувьд хүрсэн байна.				100%	

						<p>272726 нь буюу 78.5% нь А,В,С хангалттай үнэлгээ авсан байна. Энэ нь нийт хүн амын 10.1% эзэлж байна.</p>	
<p>2.2.</p>	<p>Арга хэмжээ 3.5.2. Улсын хэмжээнд иргэдийн спортын төрөлжсөн наадмыг 4 жил тутамд зохион байгуулна.</p>	<p>Улсын төсөв 165,0 сая төгрөг</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>Иргэдийн наадам зохиогдсон байна</p>	<p>Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын дагуу "Монголын Оюутны спортын наадам"-ыг 2 жил тутамд зохион байгуулдаг. 2022 онд Монголын оюутны спортынV наадам эхний хагас жилд спортын 10 төрлөөр 29 их, дээд сургууль хамрагдсан. Улсын хэмжээний анхан шатын тэмцээнд 4500 тамирчид, шигшээ наадамд 1607 тамирчид хамрагдаж амжилтаараа медаль хүртсэн 459 тамирчин, дасгалжуулагч холбогдох журмын дагуу 176.400.0 сая төгрөгийн мөнгөн шагнал олгохоор боллоо. Монголын үндэсний спортын наадмыг 4 жил тутамд нэг удаа зохион байгуулагдаж 2022 онд өвлийн 2 төрлийг 2 сард, зуны 13 төрлийн тэмцээнийг 8 сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан. шигшээ тэмцээнд 21 аймаг, 9 дүүргийн 2648 тамирчид 53 багц, 561 медалийн төлөө өрсөлдсөн. Даргын 2022 оны А/144 дүгээр тушаалаар 349, 5 сая төгрөгийн зардлыг Монголын үндэсний спортын хороотой 135 дугаар гэрээ байгуулан ажилласан. "Монголын үндэсний спортын VII наадам"-д медаль авсан 294 тамирчин, дасгалжуулагчдад Засгийн газрын тогтоолын дагуу 117,600,000 төгрөг мөнгөн шагнал олгохоор боллоо. Монголын бүх ард түмний спортын наадмын 4 жил тутамд зохион байгуулахаар тогтосон. "Монголын бүх ард түмний спортын XV зуны наадам"-ыг 2022 онд хоёрдугаар хагас жилд зохион байгуулагдаж олимпын спортын 18 төрөл, оюуны спортын 2 төрөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын 6 төрөл, нийт</p>	<p>100%</p>

	<p>Арга хэмжээ 3.5.3. Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд, заавал биелүүлэх нормативыг ангиллаар мөрдүүлнэ.</p>	<p>Улсын төсөв</p>	-		<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг</p>	<p>26 спортын төрөлд 4500 гаруй тамирчид оролцож, 1198 тамирчин, дасгалжуулагчид медаль авах бөгөөд Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолын дагуу 1,161.5 сая төгрөгийн мөнгөн шагнал олгохоор боллоо.</p>	
<p>2.3.</p>	<p>Биеийн жингийн индекс, сорилын үзүүлэлтэд суурилсан дасгал хөдөлгөөний жорын санг бүрдүүлэх стандарт боловсруулах ажлын хүрээнд БНСУ-н "Сорил-100" хөтөлбөр, Европын холбооны Еврофит, Эрүүл мэндийн фитнесийн "Alpha-Fit", Казакстан болон Япон улсын сорилын программ хөтөлбөрүүдийг судалж бие бялдрын түвшин тогтоох сорилын цахим сангийн өгөгдлийн ажлын даалгавар, 2005 онд батлагдсан MNS:5538 "Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ" стандартыг шинэчлэн боловсруулж батлуулах саналыг Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлэн ажилласан.</p> <p>Мөн Оросын холбооны улсын "Хөдөлмөр батлан хамгаалахад бэлэн" хөтөлбөртэй танилцах 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Улаан-Үүд хотод очиж хөтөлбөрийн үйл ажиллагаа, спортод өсвөрийн насны тамирчдыг сонгох, спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв, спортын барилга байгууламжийн үйл ажиллагаатай танилцаж мөргөжил дээшлүүлэх 6 хоногийн сургалтад хамрагдсан.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2005 онд батлагдсан MNS:5538 "Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ" стандартад заагдсан нас насны ангиллын норм, нормативыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>					<p>100%</p>	

2.4.	<p>Арга хэмжээ 3.5.4. Хүн амын амьдралын хэв маягийг дэмжих, идэвхтэй амьдралын аж төрөх ёсны хэрэглээг дэмжсэн судалгаа, сургалт, сурталчилгааг нэмэгдүүлнэ.</p>	Улсын төсөв	-	-	-	<p>Хүн амын идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих зорилгоор иргэдийн дунд иог, алхалт, гүйлт, дугуй зэрэг 6 удаагийн арга хэмжээг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж 182 байгууллагын 71850 хүн хамрагдсан байна.</p> <p>Мөн төрийн албан хаагчдын ажил мэргэжлийн онцлогт уялдуулан бие бялдрын хөгжил, хөдөлгөөний идэвхийг тодорхойлох судалгааг ЭМЯ, НЭМҮТөвтэй хамтран улсын хэмжээнд түүврийн аргаар 2 аймаг, 2 дүүргийн 478 төрийн албан хаагчдаас судалгааг аваад байна.</p> <p>Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол Хүн Хөдөлгөөн”, ТББ-тай хамтран иргэдийн хандлага, идэвхтэй амьдралыг сурталчилсан сургалт, хэлэлцүүлгийг 6 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 83 байгууллагын 600 гаруй хүн хамруулан үйл ажиллагаа сургалт, сурталчилгааны ажлыг нэмэгдүүллээ.</p>	100%
2.5.	<p>Арга хэмжээ 3.5.5. Олон улсын шаардлага, стандартад нийцсэн орчинд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.</p>	Улсын төсөв	-	-	-	<p>Улсын хэмжээнд 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар спорт цогцолбор 4, спорт заал 6, наадмын талбай 1, хөл бөмбөгийн талбай 1, мөсөн ордон 1, усан бассейн 1 нэмэгдэн ашиглалтад орж спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлсэн.</p> <p>Биеийн тамир, спортын салбарын үр дүнд суурилсан санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх, биеийн тамир, спортын үйлчилгээ хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр бичиг баримтыг боловсруулан санал авахаар Сангийн яаманд хүргүүлсэн.</p>	80%

2.6.	<p>Арга хэмжээ 3.5.6. Биеийн тамир, спортын үйлчилгээний төрөл, гүйцэтгэлтэй уялдсан хараат бус магадлан итгэмжлэл бүхий чанарын удирдлагыг нэвтрүүлнэ.</p>	Улсын төсөв	-	-	-	<p>Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан "Журам батлах тухай" А/178, А/144 тоот тушаалаар "Спортын клубийг магадлан итгэмжлэх журам", хоёрдугаар хавсралтаар "Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт", гуравдугаар хавсралтаар "Магадлан итгэмжлэх үйлчилгээний төлбөрийн хэмжээ" - г тус тус баталсан. Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээний урамшуулалд эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх урамшуулал"-ын тогтолцоог бий болгосон. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ гэснийг хүчингүй болгосон. 2022 оны байдлаар улсын хэмжээнд 16 клуб магадлан итгэмжлэлийн шалгуур хангасан байгаагаас Улаанбаатар хотод 10, Сүхбаатар аймагт 1, Орхон аймагт 3, Сэлэнгэ аймагт 1, Дархан-Уул аймагт 1 клуб тус тус магадлан итгэмжлэгдсэн байна.</p> <p>Улсын хэмжээнд магадлан итгэмжлэлийн 28 хараат бус шинжээчдийн давтан сургалтыг 11 сарын 23-24-ны өдрүүдэд зохион байгуулсан.</p>	80%
2.7.	<p>Арга хэмжээ 3.5.7. Биеийн тамир, спортын санхүүжилтийг боловсронгуй болгож, хувь хүний хэрэгцээг хангасан байдал, чанартай үйлчилгээ, гарц болон гүйцэтгэлд тулгуурлан санхүүжүүлнэ.</p>	Улсын төсөв	-	-	-	<p>Нийгмийн салбаруудыг үр дүнд суурилсан санхүүжилтэд шилжүүлэхтэй холбоотойгоор биеийн тамир, спортын салбарын санхүүжилтийн норм, аргачлалыг шинээр боловсруулж, хувь хүний хэрэгцээг хангасан байдал, чанартай үйлчилгээ, үр дүнгийн гүйцэтгэлд тулгуурлан санхүүжүүлэх механизмыг бүрдүүлэхээр "Орон нутгийн биеийн тамир, спортын төсвийн зарлага тооцох аргачлал"-ыг боловсруулан Сангийн</p>	50%

						<p>яаманд танилцуулсан. Мөн биеийн тамир, спортын салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын орон тооны норм, аргачлалыг боловсруулж байна.</p> <p>Нэгдсэн цахим сангийн хүрээнд техник хангамжийг бүрдүүлэн, төр ба төрийн бус байгууллагуудын ашиглагдаж байгаа мэдээллийн санг нэгтгэн спортын тэмцээн, наадмын систем, спортын цол, зэргийн систем, статистикийн дэд систем, сорилын систем, үндэсний шигшээ багийн дэд системийн хөгжүүлэлтийг тус тус хийж нэгдсэн байдлаар зохион байгуулан мэдээллийн сангийн үйл ажиллагааны хөгжүүлэлт хийгдэж байна. Спортын цол, зэргийн олголтын үйлчилгээг 2022 онд төрийн мэдээллийн нэгдсэн emongolia порталд холбох ажлын хүрээнд цахим хөгжүүлэлтийн ажил 60% явагдаж байна.</p>	
2.8.	<p>Арга хэмжээ 3.5.8 Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн технологийн удирдлага, зохион байгуулалт үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн нэгдсэн бааз, платформ бий болгоно.</p>	Улсын төсөв	-	Мэдээллийн сангийн үйл ажиллагаа эхлүүлсэн байна.	Салбарын 1 ажил, үйлчилгээг цахимаар үзүүлдэг болсон байна.	60%	
2.9.	<p>Арга хэмжээ 3.5.9. Биеийн тамир, спортын технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.</p>	Улсын төсөв	-	-	-	<p>Биеийн тамир, спортын технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, шинэ дэвшилтэд технологи нэвтрүүлэх чиглэлээр Солонгосын шинжлэх ухааны институтгийн төлөөлөгч нар Улаанбаатар хотод айлчлан ирж санал солилцох, туршлага судлах уулзалт зохион байгуулсан. Уулзалтаас дараах үр дүн гарсан. Үүнд:</p> <p>-Талууд спортын салбарт яам хооронд хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг шинэчлэн байгуулах ажлыг 2 улсын Гадаад харилцааны яамдаар дамжуулан эхлүүлэх;</p> <p>-БНСУ-ын жишиг хөтөлбөр, сайн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор “Иргэдийн бие бялдрын сорилын 100 төв”-н үйл ажиллагаа, 100%</p>	

2.10.	Арга хэмжээ 3.5.10. Биеийн тамир, спортын үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн	Улсын төсөв	-	-	-	<p>техник технологийн туршлагыг судлан Монголд шат дараатайгаар нэвтрүүлэх; -Спортын шинжлэх ухааны олон улсын эрдэм шинжилгээний хурал хамтран зохион байгуулах, -Оюутан солилцох, албан хаагчдыг богино хугацааны сургалтад хамруулах; -Тоног төхөөрөмж, хэрэглэл материалаар дэмжлэг үзүүлэх; -ODA олон улсын төсөл хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; Монгол Улсын Боловсролын Их сургуулийн Биеийн тамирын сургуультай хамтран "Биеийн тамирын боловсрол, спортын хөгжил-2022" олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2022 оны 04 дүгээр сард зохион байгуулсан. Уг эрдэм шинжилгээний хурлаар 32 эрдэмтэн судлаачид илтгэл тавьж оролцон биеийн тамир, спортын салбарын инновац, дэвшилтэд технологийн талаар хэлэлцсэн. Мөн Оросын холбооны улсын "Хөдөлмөр батлан хамгаалахад бэлэн" хөтөлбөртэй танилцах 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүүхдийг спортод сонгон шалгаруулах тоног төхөөрөмж хэрэглэл материал, Хөдөлмөр батлан хамгаалахад бэлэн хөтөлбөрийн тоног төхөөрөмжүүдийн дэмжлэг авах чиглэлээр Оросын холбооны улсын Буриадын Спортын сайд болон Буриадын их сургуультай ярилцаж санал солилцлоо.</p>	<p>"Орон нутгийн биеийн тамир, спортын төсвийн зарлага тооцох аргачлал"-ыг боловсруулахдаа биеийн тамир, спортын үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, шилжилт</p>
-------	--	-------------	---	---	---	---	--

	<p>бүтэц, хөдөлгөөн, үйлчилгээний хэрэгцээтэй шилжилт тусламж, эрэлт уялдуулан зохион байгуулна.</p>				<p>хөдөлгөөн, тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулсан байдлаар боловсруулсан бөгөөд тухайн орон нутгийн онцлог, хүн ам зүйн бүтэц, шилжилт хөдөлгөөний үр дүнгээр бий болж буй хүн амын өсөлт, бууралтын хувиар зохицуулалт хийх боломжийг бүрдүүлсэн.</p> <p>“Орон нутгийн биеийн тамир, спортын төсвийн зарлага тооцох аргачлал”-д тусгасан гол асуудлын нэг нь төр, төрийн бус байгууллагын түншлэлээр ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн бөгөөд төрийн бус байгууллагын үйлчилгээний эрэлт, хэрэгцээ, үр дүнтэй санхүүжүүлэх зохицуулалтыг бүрдүүлсэн.</p>	80%
2.11.	<p>Арга хэмжээ 3.5.11. Биеийн тамир, спортын хөтөлбөрөөр сургалт эрхэлж байгаа байгууллагад зөвшөөрөл, тусгай итгэмжлэлд магадлан шаардлагыг тавигдах шинэчилж, чиг үүргийг нь хараат бус, мэргэжлийн байгууллагад шилжүүлнэ.</p>	Улсын төсөв			<p>Монгол Улсын Их Хурлаас 2017 онд Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлахдаа Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд тодорхой нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бөгөөд магадлан итгэмжлэгдсэн спортын клубт 3 сар тогтмол хичээллэсэн иргэнд спортоор хичээллэсэн төлбөрийн тодорхой хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулал хэлбэрээр олгож байсныг 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон. Улсын хэмжээнд одоогоор 16 спортын клуб магадлан итгэмжлэгдэн үйл ажиллагаа явуулж байна.</p>	0%
2.12.	<p>Арга хэмжээ 3.5.12. Хүүхэд, залуучуудын авьяасыг нээх, шилдэг тамирчдыг бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно.</p>	Улсын төсөв			<p>2022 оны байдлаар улсын хэмжээнд 9 дүүрэг 18 аймагт засаг даргын дэргэдэх есвөрийн шигшээ багийн тамирчид байнгын бэлтгэл сургуулилт хийж ажиллаж байна. Улсын хэмжээнд 33 спортын төрөлд 5395 тамирчин үүнээс эрэгтэй 3196 эмэгтэй 2199 хүүхдүүд хичээллэж байна. Хичээллэгсдийг насны</p>	100%

						<p>ангилаар авч үзвэл 10 хүртэлх насны 1094, 10-14 хүртэлх насны 2216, 15-18 хүртэлх насны 2188 тамирчин ажиллаж байна. Өсвөрийн тамирчид энэ онд 1287 спортын тэмцээнд оролцож 1208 алт, 1036 мөнгө, 1419 хүрэл медаль хүртэж тамирчдад 84.040.000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгож, тэмцээн уралдаан бэлтгэл сургууллт, хэрэглэл материалд 485.023.408 төгрөгийн санхүүжилт зарцуулсан. Өсвөрийн шигшээ багийн тамирчдаас бие бялдрын ерөнхий хөгжил, тамирчны ажиллах чадвар, бэлтгэл дасгалжуулалтын түвшнийг тодорхойлох, хоол шим тэжээл, сэтгэл зүйн байдлыг тодорхойлох түүвэр судалгааны төслийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хэрэгжүүлж эхэлсэн. 2022 онд Архангай, Баянхонгор, Говьсүмбэр Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн нийт 177 өсвөрийн тамирчдаас дээрх судалгааг авч холбогдох дүгнэлтийг хийсэн.</p>	<p>Агентлагийн даргын 2021 оны А/74 дүгээр тушаалаар "Дасгалжуулагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хичээлийн хөтөлбөр" -ийг баталсан. Батлагдсан хөтөлбөрийн дагуу "Төгсөлтийн дараах дасгалжуулагчийн мэргэшүүлэх сургалт"-ыг МУБИС-ын Биеийн тамирын сургуультай хамтран Аймаг, нийслэл, дүүргийн спортын газар, хороо, спортын холбоо, клубийн багш, дасгалжуулагчдыг мэргэжил, арга зүйгээр хангах сургалтад хамрагдах 53 хүний сургалтын зардалд 68,9 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Аймаг, дүүрэгт ажиллаж байгаа 30, спортын холбоодод ажиллаж байгаа 23, нийт 53 Биеийн тамирын дээд сургуулийг бакалавраар төгссөн</p>
2.13.	<p>Арга хэмжээ 3.5.13. Биеийн тамир, спортын нэн шаардлагатай болон тэргүүлэх чиглэл, мэргэжлээр хүний нөөц бэлтгэх, орон нутгийн хэрэгцээг хангах чиглэлээр хүний нөөцийг төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>	Улсын төсөв	-	-		50%	

					<p>төгсөгчид 20 кредитийн 7 хичээл, 8 долоо хоног үргэлжлэх сургалтад 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн хамрагдсан. Агентлагийн даргын 2021 оны А/167 дугаар тушаал "Биеийн тамирын арга зүйчийн мэргэшүүлэх давтан сургалтын хөтөлбөр"-ийг баталсан. Улсын хэмжээнд 100 арга зүйч ажиллаж байгаа ба "Эрүүл Монгол Хүн Хөдөлгөөн"-ий хүрээнд Баянхонгор аймгийн 19 сумын биеийн тамирын арга зүйчдэд хууль тогтоомж салбарын бодлого шийдвэрийг танилцууллаа.</p> <p>Биеийн тамирын их дээд сургуульд сурч байгаа оюутнуудыг Оросын холбооны улсад мэргэжил дээшлүүлэх, давтан сургах талаар судалгааг авахад Аварга БТД Сургуулиас З, Мон-Алтиус БТДС-иас 7 нийт 10 оюутны судалгааг ирүүлсэн.</p>
--	--	--	--	--	--

ХЯНАСАН: Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

О.Багтулга

ТАНИЛЦСАН: Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга

Б.Нямсүрэн

Биеийн тамирын хэрэгжилтийн хэлтсийн дарга

О.Баасан

Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтсийн дарга

Н.Оюунбат

Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга

Э.Билэгт

Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Б.Долгион

Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн

С.Мөнх-Эрдэнэ

НЭГТГЭСЭН:

ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн



Ц.Багцайз



“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2022.11.25

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монголын Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтын хүрээнд Биеийн тамир, спортын салбарын хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулж, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үндэслэл, үнэлгээний арга зүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2022 оны жилийн эцсийн тайлан ажлын бодит үр дүнг, хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцлоо.

Үүнд:

- “үр дүнтэй” 100 хувь;
- “тодорхой үр дүнд хүрсэн” 70 – 99 хүртэл хувь;
- “эрчимжүүлэх шаардлагатай” 31 – 69 хүртэл хувь;
- “үр дүнгүй” 0- 30.0% үнэлгээг гаргалаа.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Биеийн тамир, спортын салбарын 2 зорилт 14 арга хэмжээний хэрэгжилтийн 2022 оны жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж зорилтын дундаж 56.65 хувьтай, буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдэж байна.

№	Дэс тугаар	Зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн хувь
ЗОРИЛГО 1. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ			
Зорилт 1.5. Дэлхий дахинд монгол үндэсний үнэт зүйлсийн дархлаа тогтож, монгол соёлыг түгээн дэлгэрүүлж, Монгол Улсын нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлж, хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатны хамтын ажиллагаа төлөвшинэ.			30%
1.	1.1.12.	Монголын уламжлалт спорт, наадам, наадгайг (бөх, сурын харваа, шагайн харваа гэх мэт) хөгжүүлэх, үндэсний баг, тамирчдаа дэмжих, морин болон тэмээн спортын (морин поло, тэмээн поло) төв байгуулж үндэсний багтай болох, гадаад, дотоодын баг, тамирчдыг урьж тоглуулах тогтолцоог хөгжүүлж, спортын зарим төрлийг олон улсын болон олимпын төрөлд оруулах, түүгээр дамжуулан өөрийн орны соёлыг түгээн дэлгэрүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.	30%
ЗОРИЛГО 3. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА			
Зорилт 3.5. Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ.			83.3%
2.	3.5.1.	Биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгох, иргэн, гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн идэвхтэй амьдралын дадал хэвшил төлөвшүүлэх насан туршийн боловсролын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	100%
	3.5.2.	Улсын хэмжээнд иргэдийн спортын төрөлжсөн наадмыг 4 жил тутамд зохион байгуулна.	100%
	3.5.3.	Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд, заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлнэ.	100%
	3.5.4.	Хүн амын идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих, идэвхтэй амьдралын аж төрөх ёсны хэрэглээг дэмжсэн судалгаа, сургалт, сурталчилгааг нэмэгдүүлнэ.	100%
	3.5.5.	Олон улсын шаардлага, стандартад нийцсэн орчинд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	70%
	3.5.6.	Биеийн тамир, спортын үйлчилгээний төрөл, гүйцэтгэлтэй уялдсан хараат бус магадлан итгэмжлэл бүхий чанарын удирдлагыг нэвтрүүлнэ.	70%
	3.5.7.	Биеийн тамир, спортын санхүүжилтийг боловсронгуй болгож, хувь хүний хэрэгцээг хангасан байдал, чанартай үйлчилгээ, гарц болон гүйцэтгэлд тулгуурлан санхүүжүүлнэ.	50%
	3.5.8.	Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн технологийн удирдлага, зохион байгуулалт үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн нэгдсэн бааз, платформ бий болгоно.	70%
	3.5.9.	Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн технологийн удирдлага, зохион байгуулалт үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн нэгдсэн бааз, платформ бий болгоно.	100%
	3.5.10.	Биеийн тамир, спортын үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, шилжилт хөдөлгөөн, тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна.	70%
	3.5.11.	Биеийн тамир, спортын хөтөлбөрөөр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж, чиг үүргийг нь хараат бус, мэргэжлийн байгууллагад шилжүүлнэ.	0%
	3.5.12.	Хүүхэд, залуучуудын авьяасыг нээх, шилдэг тамирчдыг бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно.	100%
	3.5.13.	Биеийн тамир, спортын нэн шаардлагатай болон тэргүүлэх чиглэл, мэргэжлээр хүний нөөц бэлтгэх, орон нутгийн хэрэгцээг хангах чиглэлээр хүний нөөцийг төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	70%
Зорилтын дундаж үнэлгээ			56.65%

Дөрөв. Дүгнэлт.

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1.5 дугаар зорилтын 1.5.12. арга хэмжээ Монголын уламжлалт спорт, наадам, наадгайг (бөх, сурын харваа, шагайн харваа гэх мэт) хөгжүүлэх, үндэсний баг, тамирчдаа дэмжих, морин болон тэмээн спортын (морин поло, тэмээн поло) төв байгуулж үндэсний багтай болох, гадаад, дотоодын баг, тамирчдыг урьж тоглуулах тогтолцоог хөгжүүлж, спортын зарим төрлийг олон улсын болон олимпын төрөлд оруулах, түүгээр дамжуулан өөрийн орны соёлыг түгээн дэлгэрүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх” арга хэмжээний хэрэгжилт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлагдсаны дараа Нийслэлийн Засаг даргын тамгын газарт асуудал шийдвэрлэгдэх болохоор байгууллага хоорондын ажлын уялдаа холбоотой удааширч байна.

2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.5 дугаар зорилтын 3.5.5 арга хэмжээ Олон улсын шаардлага, стандартад нийцсэн орчинд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох баримт бичиг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн.

3. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.5 дугаар зорилтын 3.5.6 арга хэмжээ Биеийн тамир, спортын үйлчилгээний төрөл, гүйцэтгэлтэй уялдсан хараат бус магадлан итгэмжлэл бүхий чанарын удирдлагыг нэвтрүүлнэ. Гүйцэтгэлийн тайлангаас харахад хэрэгжилтийг ерөнхий байдлаар тайлагнасан бодит үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй, шалгуур үзүүлэлтээ хангасан эсэх ойлгомжгүй байна.

4. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.5 дугаар зорилтын 3.5.11. Биеийн тамир, спортын хөтөлбөрөөр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж, чиг үүргийг нь хараат бус, мэргэжлийн байгууллагад шилжүүлэхэд эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулал хэлбэрээр олгож байсныг 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон.

Тав. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ / зөвлөмж /

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1.5 дугаар зорилтын 1.5.12. дэх хэсэгт заасан Монголын уламжлалт спорт, наадам, наадгайг (бөх, сурын харваа, шагайн харваа гэх мэт) хөгжүүлэх, үндэсний баг, тамирчдаа дэмжих, морин болон тэмээн спортын (морин поло, тэмээн поло) төв байгуулж үндэсний багтай болох, гадаад, дотоодын баг, тамирчдыг урьж тоглуулах тогтолцоог хөгжүүлж, спортын зарим төрлийг олон улсын болон олимпын төрөлд оруулах, түүгээр дамжуулан өөрийн орны соёлыг түгээн дэлгэрүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Бодлого, төлөвлөлтийн газар, Спортын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтэс.

2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.5 дугаар зорилтын 3.5.5 арга хэмжээ Олон улсын шаардлага, стандартад нийцсэн

орчинд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд холбогдох боловсруулсан бичиг баримтыг эрчимжүүлэхийг Бодлого, төлөвлөлтийн газар.

3.“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.5 дугаар зорилтын 3.5.6 арга хэмжээ Биеийн тамир, спортын үйлчилгээний төрөл, гүйцэтгэлтэй уялдсан хараат бус магадлан итгэмжлэл бүхий чанарын удирдлагыг нэвтрүүлэх хэрэгжилтийг тодорхой тайлагнахыг Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын хэлтэс.

4. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж, холбогдох нэгжид шаардлага тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газарт тус тус зөвлөмж хүргүүлж байна.

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
ХШУДАХ-ИЙН ДАРГА



Н.БАТСҮХ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:
ХШУДАХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



О.БОЛОРМАА